

## ГАРЧИГ

|  |    |
|--|----|
| 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....   | 3  |
| 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....                      | 9  |
| 2.1 Төв аймгийн Аргалант сумын байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....                        | 9  |
| 2.2. Төслийн талбайн өнөөгийн газрын гадарга, төлөв байдал .....   | 10 |
| 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....   | 14 |
| 3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа.....  | 14 |
| 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....   | 16 |
| 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....  | 17 |
| 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....   | 20 |
| 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....  | 21 |
| 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....   | 22 |
| Цаашид дахин ашиглах боломжтой хаягдлыг аль болох дахин ашиглах хувь хүн, байгууллагуудад нийлүүлж хог хаягдлын хэмжээг .....  | 22 |
| бууруулж ажиллах хэрэгтэй. ....  | 22 |
| 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....  | 24 |
| 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....             | 25 |
| 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 26 |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000507294 дугаартай 7.5 га газрын булангийн цэгүүд .....   | 3  |
| Хүснэгт 2. Аргалант сумын газрын сангийн ангилал .....  | 9  |
| Хүснэгт 3. Төслийн талбайн ашиглалт, физик, хими болон биологийн эвдрэл .....   | 10 |
| Хүснэгт 4. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр .....   | 14 |
| Хүснэгт 5. 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал..   | 16 |
| Хүснэгт 6. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ.....  | 17 |
| Хүснэгт 7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....  | 20 |
| Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....   | 21 |
| Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....   | 22 |
| Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....  | 24 |
| Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....              | 25 |
| Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө ..... | 26 |

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|  |    |
|--|----|
| Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг .....                              | 4  |
| Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг .....                         | 5  |
| Зураг 3. “Жирмийн цагаан нуур” жуулчны баазын ресторан .....                       | 7  |
| Зураг 4. "Жирмийн цагаан нуур" жуулчны баазын монгол гэр сууц .....                | 7  |
| Зураг 5. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз дахь гадаад дотоодын .....             | 7  |
| Зураг 6. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз дахь спортын танхим.....               | 8  |
| Зураг 7. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз дахь сагс, волейболын талбай.....      | 8  |
| Зураг 8. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз боловсон ариун цэврийн байгууламж..... | 8  |
| Зураг 9. “Хос-Оюу” ХХК-ийн “Жирмийн цагаан нуур” жуулчны баазын талбайн .....      | 11 |
| Зураг 10. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөр (метр).....                 | 12 |
| Зураг 11. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус) .....              | 13 |

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр** : “Жирмийн цагаан нуур” жуулчны баазын төсөл

**Төслийн зорилго**: Уул толгодоор хүрээлэгдсэн, цэцэг навч алагласан, цэнгэг агаартай байгалийн үзэсгэлэнт газар дотоодын жуулчид төдийгүй гадаадын жуулчдыг түлхүү хүлээн авч XIII зуун, Монголын эзэнт гүрний түүх соёл, ёс заншил, онгон байгальтай танилцуулах, алжаалыг нь тайлахуйц дээд зэрэглэлийн үйлчилгээ үзүүлэх зорилготой.

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг**:

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:

- “Хос-Оюу” ХХК
  - Хувийн хэргийн дугаар:9011009028
  - Регистрийн дугаар: 2652323

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, 4-р хороолол, 29 -53 тоот
- Утас: 976-99145233

**Төслийн байршил**:


Төв аймгийн Аргалант сумын нутагт байрладаг ба Улаанбаатараас 50 км зайд оршдог.

- Талбайн хэмжээ: 7.5 га
- Талбайн байр зүйн зургийн нэрлэбэр: L-48-9


**Газарзүйн солбицол**

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000507294 дугаартай 7.5 га газрын булангийн цэгүүд

| № | Уртраг |       |        | Өргөрөг |       |        |
|---|--------|-------|--------|---------|-------|--------|
|   | градус | минут | секунд | градус  | минут | секунд |
| 1 | 106    | 7     | 55.0   | 47      | 56    | 28.6   |
| 2 | 106    | 7     | 55.1   | 47      | 56    | 35.5   |
| 3 | 106    | 8     | 12.1   | 47      | 56    | 34.9   |
| 4 | 106    | 8     | 11.7   | 47      | 56    | 28.0   |



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршилны зураг



Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

**Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал:**

“Хос-Оюу” ХХК нь анх 2000 онд анх байгуулагдсан цагаасаа эхлэн Япон улсын жуулчдыг хүлээн авч, майхангай, морин аялал явуулдаг байсан. 2007 онд “Жирмийн цагаан нуур” жуулчны баазыг байгуулан Япон, Франц, ХБНГУ болон дотоодын аялал жуулчлалын компаниудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж гадаад, дотоодын жуулчин хүлээн авч үйлчилж Монгол улсад байнга болон түр оршин сууж байгаа гадаадын иргэдийг хүлээн авах/domestic/ үйл ажиллагаа явуулсаар байна.

Нэг ээлжиндээ 60-80 хүн хүлээн авах хүчин чадалтай. Жуулчдыг тав тухтай байлгах алжаал ядаргаа тайлахуйц дээд зэрэглэлийн үйлчилгээ үзүүлэх зорилготой ажилладаг. Хурал зөвлөгөөн, нийтийн бүжиг, хүндэтгэл, ёслолын арга хэмжээ зохион байгуулах танхим бүхий 80 хүний суудалтай орчин үеийн рестаронтай.

**Төслийн үндсэн тоног төхөөрөмж:**

- Ресторан- 1ш
- Монгол гэр- 20ш
- Тоосгон гэр сууц-1ш
- Бэлэг дурсгалын дэлгүүр-1ш
- Хүүхдийн тоглоомын талбай-1ш
- Спортын танхим- 1ш
- Сагс, волейболын талбай-1ш
- Агуулах-2 ш
- Зоорь- 1 ш
- Боловсон ариун цэврийн байгууламж- 1ш
- Угаалгын өрөө-1ш
- Шүршүүр- 4ш
- Бага оврын цахилгаан дэд станц- 1ш
- Машины зогсоол
- Хүлэмж -1 ш
- Ногоон байгууламж
- Тарианы талбай
- Ажилчдын байр-1ш
- Хувийн зуслангийн байшин сууц-1 ш
- Эргэн тойронд явган хүний зам, гэрэлтүүлэг

**Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц:**


- *Усан хангамж:* Унд, ахуйн хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана;
- *Бохир ус зайлуулах:* Бохироо 5 тонны 2 ширхэг ёнкост хуримтлуулан гэрээний дагуу тогтмол соруулдаг;
- *Цахилгаан эрчим хүч, дулааны хангамж:* Бага оврын 380В-ын цахилгааны дэд станцтай;
- *Харилцаа холбоо:* Үүрэн холбооны операторууд болох Mobicom, Skytel, Unitel, G-mobile операторуудын сүлжээгээр холбоо барих бүрэн боломжтой;



Зураг 3. “Жирмийн цагаан нуур” жуулчны баазын ресторан



Зураг 4. Жирмийн цагаан нуур” жуулчны баазын монгол гэр сууц



Зураг 5. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз дахь гадаад дотоодын жуулчдад зориулсан бэлэг дурсгалын дэлгүүр



Зураг 6. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз дахь спортын танхим



Зураг 7. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз дахь сагс, волейболын талбай



Зураг 8. “Жирмийн цагаан нуур” жуулчны бааз боловсон ариун цэврийн байгууламж



## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Төв аймгийн Аргалант сумын байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

**Товч тодорхойлолт:** Төв аймгийн Аргалант сум 1977 онд атар газар эзэмших 2 дахь аяны жил байгуулагдсан. Тус сум 112,6 мянган га газар нутагтай, тариалангийн 15850 га талбай, 85703 га малын бэлчээртэй өргөн уудам өгөөж баян нутагтай. Аргалант сум нь ургамал газарзүйн ангиллаар Монгол дагуурын дүүрэгт хамаарагдах бөгөөд монголын их хээр рүү түрж орсон ойт хээр боловч зарим газартаа элсэн оорцог толгодтой, тэнд нь говийн ургамал ургадаг, байгалийн өвөрмөц тогтоцтой нутаг юм. Мөн өндөр нь далайн түвшнээс 1100-1800 м, хамгийн өндөр цэг Хустай ханы оргил Хөшөөт 1843 м, хамгийн нам цэг Тариатын булаг 1190 м.

**Уур амьсгал:** Уур амьсгалын мужлалын хувьд чийглэг, сэрүүн нэн хүйтэн; хуурайдуу, сэрүүвтэр хүйтэн, нэн хүйтэн бүсүүдэд оршдог.

**Газрын гадаргуу:** Төв аймгийн нутгийн ихэнх хэсэг далайн түвшнээс дээш 1200-1500 метр өргөгдсөн, Хэнтийн нуруу оргил нь (Асралт хайрхан 2800 м), Тосон замар, Зоргол хайрхан зэрэг уулархаг гадаргуутай. Нутаг дэвсгэрийнх нь 16.4% нь ой мод, 36.5% нь хээрийн бүс эзэлдэг. Газар зүйн байршлаар хангай Хэнтий уулархаг Дорнод Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй. Өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм.

**Ургамалжилт:** Монгол орны Ургамал-газар зүйн мужлалаар Төв аймгийн Аргалант сумын нутаг болон төслийн талбай нь Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарна (Өлзийхутаг, 1989). Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт төрөл бүрийн хувилбараар тохиолдох уулын хээрийн ургамалжилт тохиолдоно. Зонхилох хээрийн хэвшлүүдэд шивээт хялгана-хазаарганад, шивээт хялгана-хазааргана-элдэв өвст, хялгана-навтуулд хээр багтах бөгөөд Дорно талдаа түнгэ, шивээт-хялгана-түнгэд, шивээт хялганат, зүр өвст хээр гол байрыг эзэлнэ.

**Газарзүйн байршлаар:** Тус сум нь аймгийн баруун хойд хэсэгт Улаанбаатар хотоос баруун зүгт 82 км зайд аймгийн төвөөс 106 км зайд байрладаг Тус сум нь хойд талаараа Баянцогт сум, зүүн талаараа Улаанбаатар хот, урд талаараа Алтанбулаг, баруун талаараа Баянхангай сумдтай хиллэдэг. Сумын нутаг далайн түвшнээс дээш 1200 м-т өргөгдсөн, элсэнцэр хөнгөн хүрэн хөрстэй, хангай говь хосолсон тансаг сайхан байгальтай, сумын нутаг дэвсгэр нь уул гүвээ толгод бүхий тал хээрийн бүс, Мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Газар хөдлөлийн эрчим 7 балл.

Хүснэгт 2. Аргалант сумын газрын сангийн ангилал

| № | Газар нутаг                   | Хэмжээ (га) |
|---|-------------------------------|-------------|
| 1 | Тусгай хэрэгцээний газар      | 8172        |
| 2 | Хөдөө аж ахуйн газар          | 102276      |
| 3 | Хот тосгон бусад суурин газар | 540         |
| 4 | Зам шугам сүлжээний газар     | 1212        |
| 5 | Ойн сангийн газар             | 424         |
| 6 | Усан сан бүхий газар          | 13          |

**Хүн ам:** Чандмань, Замт, Эрдэнэ гэсэн 3 багийн нийт 1131 өрхөд 3603 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 26 сумаас эхнээсээ 6-д, газар нутгийн хэмжээгээр 26-д ордог. Хүн амын нягтралаар хамгийн өндөр /5.49 хүн/га/ сум юм.

**Эдийн засаг, аж үйлдвэр:** Сумын хэмжээнд нийт 26 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Тус сум улсад 13.5сая,аймагт 68.3 сая, орон нутагт 7.7сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.Сумын эдийн засгийн голлох салбар бол газар тариалан мал аж ахуйн үйлдвэрлэл юм. Байгаль орчны доройтлыг сааруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилго бүхий малчны бүлэг байгуулагдан ажиллаж байна.

**Газар тариалан:** Сумын хэмжээгээр жилд 1531 га талбайд үр тариа, 30 га талбайд төмс, 5.5 га талбайд хүнсний ногоо, 690 га талбайд тэжээлийн ургамал тариалж 1453 тонн үр тариа, 388 тонн төмс, 50.2 тонн хүнсний ногоо, 2000 тонн тэжээлийн ургамал хураан авдаг.

**Зам тээвэр:** Сумын газар нутаг дээгүүр “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн улсын чанартай хатуу хучилттай авто зам 116 км урттай дайран өнгөрдөг. Хөдөөгийн малчид, багийн иргэд, аж ахуйн нэгжүүд хоорондоо шороон замаар холбогддог.

**Орон сууц хангамж:** Суманд инженерийн бүрэн хангамжтай орон сууцгүй. Айл өрхүүд амины сууц болон гэр сууцанд амьдарч байна.

**Цахилгаан хангамж:** Сум нь төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. 110/35/10 квт-ын дэд станцтай. Малчид, мал бүхий иргэдийн 98 хувь нь нар, салхины сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж байна. Эрчим хүчний системд аялал жуулчлалын Нарлаг ХХК, Хусан баганат, Жирмийн сайхан, Хос оюу, Жикс, Тусжин, Хос бэрс зэрэг аж ахуйн нэгж, компани, дахин дамжуулах 2 станц, үүрэн холбооны станцууд төвийн эрчим хүчээр хангагддаг.

**Боловсрол:** Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 11 бүлэгт 208 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 10 иргэн суралцаж байна.

**Эрүүл мэнд :** Аргалын –Уул багийн төвд байрлалтай 8 ортой, 2 их эмч, 2 багийн эмч, 1 эх баригч, 4 сувилагчтай нийт 21 ажиллагчидтай.

## 2.2. Төслийн талбайн өнөөгийн газрын гадарга, төлөв байдал

“Хос-Оюу” ХХК-ийн “Жирмийн цагаан нуур” жуулчны баазын төслийн талбай нь газрын гэрчилгээний 000507294 дугаартай аялал жуулчлалын зориулалттай 7.5 га газар байрлана. Өөрийн эзэмшлийн барилга байгууламж, гэр сууцтай бөгөөд бүрэн тохижуулсан.

### Хүснэгт 3. Төслийн талбайн ашиглалт, физик, хими болон биологийн эвдрэл


| Газар ашиглалтын төрөл               | Талбай, /га/ | Бохирдлын төрөл |        |           |
|--------------------------------------|--------------|-----------------|--------|-----------|
|                                      |              | Физикийн        | Химийн | Биологийн |
| Нийт эзэмшил газар                   | 7.5          | -               | -      | -         |
| А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай | 7.5          | -               | -      | -         |
| 1.Үйл ажиллагаанд өртөөгүй           | 7.06         | -               | -      | -         |
| 2.Үйл ажиллагаанд өртсөн             | 0.44         | 0.44            | -      | -         |
| үүнээс   Барилга байгууламж          | 0.09         | 0.09            | -      | -         |

| Газар ашиглалтын төрөл | Талбай, /га/ | Бохирдлын төрөл |        |           |
|------------------------|--------------|-----------------|--------|-----------|
|                        |              | Физикийн        | Химийн | Биологийн |
| Гэр                    | 0.07         | 0.07            | -      | -         |
| Ногооны талбай         | 0.28         | 0.28            | -      | -         |


Төслийн талбайд хүний үйл ажиллагааны нөлөөгөөр (5.86%) нь эвдрэлд өртсөн байна. Газрын гадаргад хужир мараа, намаг ажиглагдаагүй. Өндөр хүчдэл, гуу жалга, үерийн ам, гал зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй байна.



Зураг 9. “Хос-Оюу” ХХК-ийн “Жирмийн цагаан нуур” жуулчны баазын талбайн фото зураг



Зураг 10. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөр (метр)



Зураг 11. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 4. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

| Байгаль орчны үзүүлэлт  | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд эрэг | Бага зэрэг |
|---|------|----------|----------------------|------------------|---------------|----------------|--------------------|--------|-----------|------------|
| <b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>  |      |          |                      |                  |               |                |                    |        |           |            |
| Газрын доорх урсцын өөрчлөлт  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Гадаргын урсцын өөрчлөлт  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт   | х    |          |                      |                  | х             |                |                    |        |           | х          |
| Хөрсний элэгдэл, эвдрэл   | х    |          |                      |                  | х             |                |                    |        |           | х          |
| Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| <b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>   |      |          |                      |                  |               |                |                    |        |           |            |
| Газрын гадаргын нөөц баялаг   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Бэлчээрийн байдал   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Эрдэс түүхий эдийн нөөц   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Эрчим хүчний нөөц   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| <b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>   |      |          |                      |                  |               |                |                    |        |           |            |
| Газрын доорх усны чанар, хэмжээ   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Гадаргын усны чанар хэмжээ  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Агаарын бохирдол  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Хөрсний бохирдол  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх            |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Дуу чимээ, шуугианы нөлөө   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| <b>4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b> |      |          |                      |                  |               |                |                    |        |           |            |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх  |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх   |      |          | х                    |                  |               |                |                    |        |           |            |

| Байгаль орчны үзүүлэлт                                       | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд эрэг | Бага зэрэг |
|--|------|----------|----------------------|------------------|---------------|----------------|--------------------|--------|-----------|------------|
| Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх                   |      |          | x                    |                  |               |                |                    |        |           |            |
| <b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>                              |      |          |                      |                  |               |                |                    |        |           |            |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх                                 |      | x        |                      |                  | x             |                |                    |        | +         |            |
| Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх                        |      | x        |                      |                  | x             |                |                    |        |           | +          |
| Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх                         |      | x        |                      |                  | x             |                |                    |        | +         |            |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх                               |      |          | x                    |                  |               |                |                    |        |           |            |
| <b>6. Эдийн засагт үзүүлэх нөлөө</b>                         |      |          |                      |                  |               |                |                    |        |           |            |
| Татварын орлого өөрчлөгдөх                                   | x    |          |                      |                  | x             |                | x                  |        |           | +          |
| Орон нутгийн орлого нэмэгдэх                                 | x    |          |                      |                  | x             |                | x                  |        |           | +          |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох                           | x    |          |                      |                  | x             |                | x                  |        |           | +          |
| Ажлын байр нэмэгдэх  | x    |          |                      |                  | x             |                | x                  |        |           | +          |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх                     | x    |          |                      |                  | x             |                | x                  |        |           | +          |
| <b>7. Бусад нөлөөлөл</b>                                     |      |          |                      |                  |               |                |                    |        |           |            |
| Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба<br>грунтын усыг бохирдуулах |      |          | x                    |                  |               |                |                    |        |           |            |
| Дүн  | 7    | 3        | 21                   | 0                | 10            | 0              | 5                  | 0      | 2         | 8          |

Тайлбар “х” сөрөг нөлөөлөл, (+) эерэг нөлөөлөл

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

*Шууд нөлөөлөл:*

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

*Шууд бус нөлөөлөл:*

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

*Хүчтэй нөлөөлөл:*

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

#### 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

*Хүснэгт 5. 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал*

| №                  | Ажлын нэр   | Зардал<br>мян.төг |
|--------------------|---|-------------------|
| 1                  | Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө  | -                 |
| 2                  | Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө  | 300.0             |
| 3                  | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө   | -                 |
| 4                  | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө   | -                 |
| 5                  | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр  | 278.0             |
| 6                  | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө             | -                 |
| 7                  | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | -                 |
| <b>Нийт зардал</b> |   | <b>578.0</b>      |



## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг бид хэрэгжүүлсэн.

Хүснэгт 6. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ

| №  | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд                | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг    | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж   | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|--|---|--|-------------------------------|-------------|------------------------|------------|------------------|--|---------------------------------|
| <b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b> |   |  |                               |             |                        |            |                  |  |                                 |
| 1  | Агаарын бохирдол үүсэх                              | Ил задгай хог хаягдал шатаахгүй байх   | Төслийн талбайд               | тогтмол     | Үйл ажиллагааны зардал |            | 2023 он          | Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016  |                                 |
| 2  | Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах | Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтрааж байх   | Төслийн талбайд               | тогтмол     |                        |            |                  |  |                                 |
| 3  |   | Мэдээллийн самбарт анхааруулга тавих   | Төслийн талбайд               | удаа        | Үйл ажиллагааны зардал |            | 2023 он          |  |                                 |
| <b>Дүн</b>   |   |  |                               |             |                        |            | -                |  |                                 |
